

UCS 0801A:2022

# НОГООН БАЙГУУЛАМЖ




Хот, суурин газрын цэцэрлэгжүүлэлт,  
ногоон байгууламжийн төлөвлөлт



# НОГООН БАЙГУУЛАМЖ

Хот, суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон  
байгууламжийн төлөвлөлт

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 20-р тогтоолоор батлав.*



## ГАРЧИГ

1. Хамрах хүрээ .....	4
2. Норматив эшлэл.....	4
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	4
4. Хот, суурин газрын ногоон байгууламжийн төлөвлөлтийн ерөнхий шаардлага .....	5
5. Хот, суурин газрын ногоон байгууламжийн ангилал.....	8
6. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж төлөвлөлтийн үндсэн шаардлага .....	9
7. Мод, бут, сөөгийн алслах зай хэмжээ.....	12
8. Хавсралт .....	16-22
Ашигласан материалын жагсаалт .....	23

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хамгаалалтын зурвасын жишээ хэлбэрүүд /Жишээ зураг/.....	6
Зураг 2. Зам дагуух ногоон байгууламжийн жишээ төлөвлөлт /Жишээ зураг/ .....	7
Зураг 3. Хоёр урсгалтай авто замын ногоон зурвасыг төлөвлөх /Жишээ зураг/.....	8
Зураг 4. Мод таримал ургамлын хослол зохиомж /Жишээ зураг/.....	10
Зураг 5. Борооны усыг ногоон байгууламжид хуримтлуулах загвар /Жишээ зураг/.....	11
Зураг 6. Ногоон байгууламжийн борооны усыг ашиглах жишээ загвар /Жишээ зураг/.....	11
Зураг 7. Барилга байгууламжийн гадна хананаас ногоон байгууламж алслах зай /Жишээ зураг/ .....	13
Зураг 8. Барилга байгууламжийн өмнөх зорчих хэсгийн ногоон байгууламжийн жишээ төлөвлөлт /Жишээ зураг/.....	13
Зураг 9. Барилга байгууламж гадна хананаас мод, сөөгний их бие хүртлэх зай хэмжээ,м / Жишээ зураг/ .....	14
Зураг 10. Авто замын хашлаганы захаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ,м /Жишээ зураг/ .....	14
Зураг 11.Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийг алслах зайн хэмжээ,м /Жишээ зураг/ .....	14
Зураг 12. Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийн алслах зай хэмжээ,м /Жишээ зураг/ .....	15
Зураг 13. Түшиц ханын дотоод ирмэг буюу улнаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ,м....	15
Зураг 14. Гудамж замын дагуух цахилгааны шугамаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ,м /Жишээ зураг/.....	15

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Цогц цэцэрлэгт хүрээлэнд тавих шаардлага.....	10
Хүснэгт 2. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ ногоон байгууламжийн хоорондын зай .....	12
Хүснэгт 3. Дамжуулах хоолой, бусад байгууламж болон ногоон байгууламжийн модны төрөл хоорондох хамгийн бага зай .....	14





**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Ногоон байгууламжид хамаарах  
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.1</sup> дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Ногоон байгууламж бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS0801A:2022 “Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн удирдамж” хотын стандарт

1.2. UCS0802C:2022 “Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах” хотын стандарт

1.3. UCS0803B:2022 “Ногоон байгууламжийн арчилгаанд тавих шаардлага” хотын стандарт


1.4. UCS0802A:2022 “Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж” хотын стандарт

1.5. UCS0801C:2022 “Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн лавлах” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.


ДАРГА



Ж. БАТБАЯСГАЛАН

1115100307

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 20  
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



## НОГООН БАЙГУУЛАМЖ

### UCS 0801A:2022 “ХОТ, СУУРИН ГАЗРЫН ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТ” ХОТЫН СТАНДАРТ

#### 1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт болон ландшафтын архитектур төлөвлөлт хийх, түүний дагуу ногоон байгууламжийн ажил гүйцэтгэхэд дагаж мөрдөнө.

#### 2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 30.01.04. Хот, тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм;
- БНБД 31-01-10. Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт;
- БНБД 32-01-04. Хот суурины гудамж, зам төлөвлөлт;
- БНБД 3.01.06.90. Барилгын орчны тохижилтын ажил;
- MNS 5973:2009. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай.

#### 3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Ландшафт** - гэж тухайн газар нутгийн ургамлын бүрхэвч, гадаргуугийн тогтцоор илэрхийлэгдэх байгалийн дүр төрх;

**Ландшафтын архитектур төлөвлөлт** - гэж хүрээлэн буй орчин, архитектурын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхой уран сайхны дүр төрх агуулсан цогц найрлагад нэгтгэн илэрхийлсэн нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалтын төлөвлөлт;

**Ногоон байгууламжийн ангилал** - гэж байршил, нутаг дэвсгэр, үйл ажиллагааны зориулалтаас хамааран ногоон байгууламжийг системчлэх;

**Авто замын дагуух ногоон байгууламж** - гэж авто замын дагуух ногоон байгууламж нь дуу чимээ бууруулах, агаарыг цэвэршүүлэх, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор замын хоёр тал болон тусгаарлах бүсэд мод, цэцэг, зүлэг таригдсан газар;

**Ургамлын улирлын шинж чанар** - гэж ургамлын навч, цэцэг, жимс, холтосны өнгө зэрэг нь улирал бүрд өөрчлөгдөх явц;

**Газрын налуу** - гэж хөрс нь байгалийн нөхцөлд хуримтлагдаж өөрөө буй болсны дараах налуу гадарга буюу газрын гадарга хоёрын хооронд үүссэн хамгийн их өнцөг;

**Өндөржилт** - гэж эх газрыг түвшний гадаргуу болгож 0 цэгээс (гадаргуугийн эхний цэг) эхлэн газрын гадаргаас хэмжих цэг хүртэлх өндрийн зай;

**Налуу газрын хамгаалалт** - гэж налуу газрын хөрс өөрчлөгдөхөөс (хөрсний нуралт)

урьдчилан сэргийлж хамгаалах ажил;

**Тулгуур хана** - гэж налууугийн хөрс нурахаас сэргийлж барьсан хана;

**Бичил цэцэрлэг** - гэж 1 га хүртэлх цэцэрлэгжүүлсэн ногоон байгууламж бүхий талбай;

**Хиймэл толгод** - гэж шороо, чулуу болон бусад материалыг ашиглан байгалийн уулын үзэмжийг дуурайлган зохиомлоор барьсан байгууламж;

**Усан дээрх байгууламж** - гэж усан сан руу амрагч, аялагчийг ойртох боломжийг бүрдүүлэх зорилгоор нуур гол далайн эрэг дээр байгуулсан байгууламж.

#### 4. ХОТ, СУУРИН ГАЗРЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийг хийхдээ “MNS 5973:2009. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай” стандартын үзүүлэлт, шаардлагуудыг заавал хангасан байх бөгөөд, нэмэлтээр заасан дараах шаардлагыг хангасан байна.

4.1. Хот, суурин газрын ногоон байгууламжийг түүний онцлогт тохируулан, экологийн нөхцөлийг алдагдуулахгүй байхаар төлөвлөнө.

4.2. Хот, суурины ногоон байгууламжийн төлөвлөлтөд дараах зарчмуудыг баримтална.  
Үүнд:

4.2.1 байгалийн ландшафтын онцлог ба уул, усны экологийн систем, түүний аюулгүй байдал, тэнцвэртэй байдлыг хамгаалах;

4.2.2 хотын экологийн хамгаалалт ба бүтээн байгуулалтын байршлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөж экологийн нэгдсэн системийг бий болгох;

4.2.3 тухайн газрын онцлогийг төлөвлөлтөд тусгах, байгалийн үзэмж, түүх, соёлын өвд түшиглэн ногоон байгууламжийн дүр төрхийг илэрхийлсэн байна.

4.3 Хотын ногоон байгууламжийн ангиллыг “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30-01-04- д заасны дагуу 3 ангилна . /Хавсралт 1,2,3/. Үүнд:

4.3.1. нийтийн эзэмшлийн ногоон байгууламж;

4.3.2. хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламж;

4.3.3. тусгай зориулалтын ногоон байгууламж.

4.4 Ногоон байгууламжийн төлөвлөлтөд хот, суурин газрын өнгө үзэмж, харагдах байдлыг ойрын болон урт хугацааны нөлөөллийг харгалзан үзнэ.

4.5 Цэцэрлэгт хүрээлэнд нийтийн тээврээр очиход зарцуулах хугацаа ойролцоогоор хотын цэцэрлэгт хүрээлэнд 30 минутаас, хорооллын цэцэрлэгт хүрээлэнд 20 минутаас ихгүй байвал зохино.

4.6 Оршин суугчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн цэцэрлэгжүүлэх талбайг сонгох ба дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- нэгээс доошгүй хотын төв замтай холбогдсон нийтийн тээврийн зогсоолын зохион байгуулалттай хослуулах;
- цэцэрлэгжүүлэх газрын хатуу хучилттай талбайн эзлэх хувийг талбайн хэлбэр



ба амрагчдын цар хүрээний дагуу тодорхойлж, нийт цэцэрлэгжүүлэх талбайн 35-аас дээшгүй хувь нь хатуу хучилттай байж болно;

- цэцэрлэгжүүлэх талбай байгуулах газарт амралт, үйлчилгээний зориулалтаас өөр зориулалттай барилга барихыг хориглоно.

4.7. Хамгаалалтын ногоон байгууламжийн төлөвлөлт нь дараах шаардлагыг хангасан байна.

4.7.1 Хот суурин газарт усны нөөц газарт ашиглах талбай, өргөлтийн насос станцын эргэн тойронд хамгаалалтын ногоон байгууламжийг байгуулж, 3-аас дээш эгнээ мод, сөөгийг төлөвлөнө.

4.7.2 Хот, суурин газрын бохир ус цэвэрлэх байгууламжийн эргэн тойронд хамгаалалтын ногоон байгууламж байгуулна.

4.7.3 Ахуйн хог хаягдлын цэгийг тойруулан хамгаалалтын ногоон байгууламжийг байгуулна.



*Зураг 1.Хамгаалалтын зурвасын жишээ хэлбэрүүд /Жишээ зураг/*

4.8 Гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн төлөвлөлт нь дараах шаардлагыг хангасан байна.

4.8.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн төлөвлөлтийг хотын гамшгаас урьдчилан сэргийлэх иж бүрэн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөнө;

4.8.2. Гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийг урт, богино ба дунд хугацааны онцгой байдлын аюулаас урьдчилан сэргийлэх ногоон бүс, хот суурин газрын тусгаарлалт орчны ногоон бүс гэсэн дөрвөн төрлийг багтаан төлөвлөнө;

4.8.3. Хотыг гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийг байгуулахдаа гол төлөв богино, дунд хугацааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн төлөвлөлтийг сонгоно.

4.8.4. Бүх түвшний гамшгаас урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн цар хүрээ, зохион байгуулалт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- урт хугацааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн хэмжээ 500 000 м<sup>2</sup>-с их байх бөгөөд үүнээс үр дүнтэй зайлсхийх талбайн хэмжээ 60% -аас их байна;
- дунд хугацааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх ногоон байгууламжийн хэмжээ 200 000м<sup>2</sup>-с их, аюулгүй бүсийн талбайн хэмжээ 40% -аас их байх;
- богино хугацааны аюулгүй ногоон байгууламжийн хэмжээ 10 000м<sup>2</sup>-с их, аюулгүй, хорогдох газрын талбайн хэмжээ 40% -аас их байна;
- онцгой байдлаас зайлсхийх ногоон байгууламжийн хэмжээ 50 000м<sup>2</sup>-с их байх бөгөөд эрсдэлээс урьдчилан сэргийлэх талбай нь 30% -аас дээш байна.


4.8.5. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх функц бүхий ногоон байгууламж нь тэгш, ил аюулгүй газарт байрлана.

4.9. Зам дагуух ногоон байгууламжийн төлөвлөлт нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


4.9.1 автозамын тусгаарлах зурвас нь хөдөлгөөний аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх бөгөөд өргөн нь 1,2м-аас багагүй байна;

4.9.2 хурдны зам, төв зам дагуух ногоон байгууламж нь хотын онцлог, хэв маяг зэргийг тусгасан үзэмжит замын сүлжээг бий болгох;

4.9.3 хот суурин газрын функциональ бүсчлэлийн онцлогтой уялдаж, цэцэрлэгийн байгалийн үзэмжийн оновчтой тодорхойлох;



Зураг 2.Зам дагуух ногоон байгууламжийн жишээ төлөвлөлт /Жишээ зураг/



*Зураг 3. Хоёр урсгалтай авто замын ногоон зурвасыг төлөвлөх /Жишээ зураг/*

4.9.4 хүрээлэн буй орчны нөхцөл байдалд тохирсон, өсөлт сайтай, гоёл чимэглэлийн шинж чанараар сайтай ургамал сонгох;

4.9.5 зам дагуух ногоон байгууламж нь 2 ба түүнээс дээш орц, гарцтай байна.

## 5. ХОТ, СУУРИН ГАЗРЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ

### 5.1. Нийтийн зориулалттай ногоон байгууламж

Нийтийн зориулалттай ногоон байгууламж нь амралтын төрөл бүрийн хэлбэрт зориулагдсан ногоон байгууламж юм.

Иргэдийг богино, урт хугацаагаар амрах, бие бялдрыг хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх боломжтой. Энэхүү нийтийн зориулалттай ногоон байгууламжийн том 1 ангилал, 6 дунд ангилал, 16-н жижиг ангилалд хуваана (Хавсралт 1).

6 дунд ангилал:

- цогц цэцэрлэгт хүрээлэн – (Н1)
- төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн – (Н2)
- ерон сууцны хорооллын ногоон байгууламж – (Н3)
- цэцэрлэгт гудамж – (Н4)
- цэцэрлэгжүүлсэн талбай – (Н5)
- байгалийн ногоон бүс – (Н6)

### 5.2. Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламж

Тухайн байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийг байгуулна. Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг хүүхдийн цэцэрлэг, спорт, соёл, боловсролын байгууллагууд, эрүүл мэнд, эрдэм шинжилгээний байгууллагууд өөрийн хэрэгцээнд тохируулан байгуулна.



Эдгээр газруудын ногоон байгууламжид дасгал хийх, спортоор хичээллэх, хүүхдүүдэд зориулан тоноглох, эмчилгээ сувилал болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, амрах зориулалттайгаар төлөвлөнө.

Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийг ахуйн нэгж, байгууллагын ажилчид, сурагчид, оюутнууд, өвчтөнүүд, эрүүл мэндийн байгууллагуудад зочлогсод ашигладаг. Энэхүү ногоон байгууламжийн 3-н дунд ангилал, 8-н жижиг ангилалд хуваана (Хавсралт 2).

3 дунд ангилал:

- сургуулийн ногоон байгууламж (X1)
- эмнэлэг, сувиллын газрын ногоон байгууламж (X2)
- дагалдах ногоон байгууламж (X3)

### **5.3. Тусгай зориулалттай ногоон байгууламж**

Тусгай зориулалтын ногоон байгууламжийг аж үйлдвэр болон тээврийн салбар байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ашигладаг. Тусгай зориулалттай ногоон байгууламжийн ангилалд хамгаалалтын ногоон байгууламж, хамгаалалтын ойн бүс, ундны усны эх үүсвэрийг хамгаалах, оршуулгын газар зэргийн хамруулан ойлгоно. Энэхүү ангиллыг 2 дунд ангилал, 2 жижиг ангилалд хуваана.

2 дунд ангилал (Хавсралт 3):

- хамгаалалтын ногоон байгууламж (Т1)
- оршуулгын газар (Т2)


## **6. ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖ ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДСЭН ШААРДЛАГА**

6.1. Цэцэрлэгт хүрээлэн дэх ногоон байгууламжийн байршлыг сонгохдоо дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- иргэд амралт, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэхэд тохиромжтой байх;
- хотын өнгө үзэмж, эрүүл тав тухтай орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах;
- уулархаг бүсэд цэцэрлэгт хүрээлэн байгуулах талбайг сонгохдоо нийт талбайн 20-оос доошгүй хувь тэгш гадаргуу байна.

6.2. Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт төгөл байгуулахдаа ашиглагдаж байгаа ногоон байгууламж, зүлэг, суулгац, усан толио бүхий талбайг хэвээр хадгална.

6.3. Ургамлын мөчир, цэцэг, навч, жимс болон титмийн хэлбэр, улирлаас хамаарах өөрчлөлтийг харгалзан зохистой байдлаар төлөвлөнө.




*Зураг 4.Мод таримал ургамлын хослол зохиомж /Жишээ зураг/*

- 6.4. Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж бүхий газар нь архитектурын жижиг хэлбэрүүд, усан оргилуур, бассейн, шат, налуу талбай, түшиц хана, сүүдрэвч, гэрэлтүүлэг гэх мэт байгууламж барьж тохижуулан тоногдсон байна.
- 6.5. Цэцэрлэгт хүрээлэн нь хүүхдийн тоглоом талбай, амралт, спортын талбай, худалдааны үйлчилгээний байгууламжууд нь хүснэгт 1-д тусгасны дагуу төлөвлөнө.


*Хүснэгт 1.Цогц цэцэрлэгт хүрээлэнд тавих шаардлага*

Байгууламжийн төрөл		Цэцэрлэгт хүрээлэнгийн хэмжээ (га)		
		10~20	20~50	≥50
1	Хүүхдийн тоглоомын талбай	●	●	●
2	Амралтын талбай	●	●	●
3	Спорт талбай	●	●	●
4	Худалдаа үйлчилгээ	●	●	●

Тайлбар: "●" -төлөвлөлтөд зайлшгүй байна гэсэн утга илтгэнэ.



Зураг 5.Борооны усыг ногоон байгууламжид хуримтлуулах загвар /Жишээ зураг/



Зураг 6.Ногоон байгууламжийн борооны усыг ашиглах жишээ загвар /Жишээ зураг/

6.6. Цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт гудамж зэргийн талбайн хэмжээ /га/-г: хотын цэцэрлэгт хүрээлэнд 15, орон сууцны хороололд 10, орон сууцанд 3, цэцэрлэгт гудамжинд 0,5 (сэргээн шинэчлэл хийхэд 0,1)-аас багагүй байхаар тооцож болно. Нийт талбайн хэмжээнд цэцэрлэгт хүрээлэн дэх ногоон байгууламжийн талбай нь 70%-иас багагүй байна.

6.7. Барилга байгууламжийн хажуугийн ногоон байгууламжийг төлөвлөхдөө дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- сүүдэрлэх хэсэгт сүүдэрт тэсвэртэй ургамал тарих;
- цонхны ойролцоо өндөр мод, бут сөөг төлөвлөхгүй байх.

6.8. Ногоон байгууламжид гаднаас шинэ төрөл, зүйлийн (сорт) ургамлыг тарималшуулахдаа хортой ургамал сонгохгүй.

6.9. Замын хоёр хажуугийн ногоон байгууламж нь 10 см хүртэл хотгор байх бөгөөд хүрээлэн буй орчны урсгал ус, хур тунадасны усыг шингээх чадамжтай борооны ус хураах ногоон байгууламжийг төлөвлөнө.

## 7. МОД, БУТ, СӨӨГИЙН АЛСЛАХ ЗАЙ ХЭМЖЭЭ

7.1. Модны төрөл зүйлийн сонголтыг төлөвлөхдөө дараахыг анхаарна. Үүнд:

- тухайн байршлын газар зүйн нөхцөлийг харгалзан ургамлын бүлгийг голлох мод, сөөг, зүлэг хослуулан төлөвлөлтийн үндсэн хэлбэрт нийцүүлсэн байх;
- ногоон байгууламжийн эдэлбэр газарт үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламжийн орчинд хортой болон өргөст ургамал тарихгүй байх;
- орон сууцны хорооллын замын хажуугийн хоёр талд, зөв хэлбэртэй, том модыг сонгох ба мөр хоорондын зайг 5.0 м-ээс 7.0 м-ийн хооронд тарина.

7.2. Модлог ургамал ба барилга байгууламж, инженерийн барилга байгууламжийн хоорондын зайн хэмжээг хүснэгт 2, 3-д харуулав.


*Хүснэгт 2. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ ногоон байгууламжийн хоорондын зай*

Барилга байгууламжийн нэр	Хамгийн бага зай (м)	
	Модны их бие хүртэл	Бут, сөөгийн их бие хүртэл
Барилга байгууламжийн гадна хананаас	5.0	2.0
Явган зам, цэцэрлэгжсэн замын хашлаганы захаас	1.0	0.7
Авто машин, троллейбусны замын зах, хашлагаас	1.5	0.6
Гудамжны зорчих хэсгийн ирмэг, замын хажуугийн хашлагаас	2.0	1.0
Түшиц ханын дотоод ирмэг буюу улнаас	1.5	0.6
Спортоор хичээллэх талбай	3.0	3.0







Зураг 7.Барилга байгууламжийн гадна хананаас ногоон байгууламж алслах зай /Жишээ зураг/



Зураг 8.Барилга байгууламжийн өмнөх зорчих хэсгийн ногоон байгууламжийн жишээ төлөвлөлт /Жишээ зураг/




Зураг 9.Барилга байгууламж гадна хананаас мод, сөөгний их бие хүртлэх зай хэмжээ,м /Жишээ зураг/



Зураг 10.Авто замын хашлаганы захаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ,м /Жишээ зураг/

Хүснэгт 3. Дамжуулах хоолой, бусад байгууламж болон ногоон байгууламжийн модны төрөл хоорондох хамгийн бага зай

№	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээ	Барилга байгууламж, зам, инженерийн шугам сүлжээний тэнхлэг	
		Шилмүүст болон навчит модны гувар, ишний тэнхлэг хүртэл /м/	Сөөг, сөөгөнцрийн гол хүртэл /м/
1	Дулаан дамжуулах яндан хоолойноос	3.0	3.0
2	Цэвэр бохир усны яндан хоолойноос	3.0	3.0
3	Цахилгаан дамжуулах кабель утаснаас	2.5	2.0
4	Троллейбус болон гэрлийн шонгоос	5.0	2.0




Зураг 11.Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийг алслах зайн хэмжээ,м /Жишээ зураг/






Зураг 12. Газар доорх шугам сүлжээнээс мод, сөөгийн алслах зай хэмжээ, м  
/Жишээ зураг/



Зураг 13. Түшиц ханын дотоод ирмэг буюу улнаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ, м  
/Жишээ зураг/



Зураг 14. Гудамж замын дагуух цахилгааны шугамаас мод, сөөгийн алслах зайн хэмжээ, м  
/Жишээ зураг/

## ХАВСРАЛТ 1.

## НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1			Нийтийн зориулалттай ногоон байгууламж	Амралтын янз бүрийн хэлбэрт зориулагдан тохижуулсан талбай.		
1.1			Н1.1	Цогц цэцэрлэгт хүрээлэн	Төрөл бүрийн гадаад үйл ажиллагаа зохион байгуулахад тохиромжтой, амрах болон үйлчилгээний байгууламж сайтай ногоон байгууламж	Талбайн хэмжээ 100000м <sup>2</sup> -аас их
1.1.1		Н1		Хотхоны цэцэрлэгт хүрээлэн	Ашиглах газар бие даасан. Амрах болон үйлчилгээний үндсэн байгууламжтай, тодорхой хотхоны хүрээний оршин суугчдын өдөр тутмын амралтын арга хэмжээ зохион байгуулахад дөхөм ногоон байгууламж байх.	Талбайн хэмжээ 10000м <sup>2</sup> -аас их байх
1.2			Төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн		Тусгай тогтсон агуулга эсхүл хэлбэртэй, амрах болон үйлчилгээний зохистой байгууламжтай ногоон байгууламж	
1.2.1		Н2	Н2.1	Ургамлын цэцэрлэгт хүрээлэн	Ургамлын шинжлэх ухааны судалгаа, нутагшуулах, ургамал хамгаалал, үзмэр, амралт, шинжлэх ухаан түгээх зэрэг арга хэмжээгээр хангах, байгууламж, тайлбар тэмдэглэл сайтай системтэй ногоон байгууламж	
1.2.2			Н2.2	Амьтны цэцэрлэгт хүрээлэн	Тэжээвэр нөхцөлд шилжүүлсэн зэрлэг амьтдыг хамгаалах, тэжээж, үржүүлэх зэрэг шинжлэх ухааны судалгаа хийх, түгээх, үзэж сонирхох, амрах зэрэг нөхцөлийг бүрдүүлсэн байгууламж бүхий цэцэрлэг	

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Tom	Дунд	Жижиг			
1.2.3			H2.3	Түүхэн цэцэрлэгт хүрээлэн	Тодорхой түүхийн үеийн төлөөллийг тусгасан цэцэрлэгийн урлаг, тусгай хамгаалалт хэрэгтэй цэцэрлэг	
1.2.4			H2.4	Туурийн цэцэрлэгт хүрээлэн	Чухал туурь болон түүнд тулгуурлаж бий болсон, туурийн хамгаалал, үзмэр зэргийн тал дээр дуурайлал болохуйц ач холбогдолтой, мөн соёл, амралтын зэрэг үүрэг ажиллагаатай ногоон байгууламж.	Түүхийн дурсгалыг хамгаалах, экологийн орчныг сайжруулах, аялал, жуулчлалтай уялдуулан төлөвлөснөөрөө онцлог
1.2.5		H2	H2.5	Тоглоомын цэцэрлэгт хүрээлэн	Томоохон хэмжээний тоглоомын байгууламжтай, экологийн орчин харьцангуй сайтай ногоон байгууламж	Ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээ 65%-тай тэнцэх эсвэл их байх.
1.2.6			H2.6	Бусад төрөлжсөн цэцэрлэгт хүрээлэн	Биеийн тамир бялдаржуулах, усан болон хотын эдэлбэр газарт байрлах байгалийн цэцэрлэгт хүрээлэн, намгархаг болон ойн цэцэрлэгт хүрээлэнг багтааж болно.	Ногоон байгууламжийн эзлэх хэмжээ 60%-аас дээш байна.
1.3				Орон сууцны хорооллын ногоон байгууламж	Амрах болон үйлчилгээний үндсэн байгууламжтай, тодорхой хүрээний оршин суугчдын өдөр тутмын амралтын арга хэмжээ зохион байгуулахад дөхөм ногоон байгууламж юм.	10000м <sup>2</sup> -аас их, хорооллын оршин суугчдад зориулагдсан.
1.3.1		H3	H3.1	Нийтийн орон сууцны ногоон байгууламж	Оршин суугчдын эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах, амрах, үйлчлүүлэхэд зориулагдсан ногоон байгууламж юм.	Өндөр давхрын орон сууцны хорооллууд хамаарна.
1.3.2			H3.2	Амины орон сууцны ногоон байгууламж	Амины сууцны эдэлбэр газарт хүүхдийн тоглоомын талбай, спортын тоног төхөөрөмжтэй талбай, амралтын талбайн ногоон байгууламж юм.	Амины эдэлбэр газартай орон сууцны ногоон байгууламж, инженерийн хангамжтай орон сууцны ногоон байгууламж байна.

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1.4			Цэцэрлэгт гудамж	Авто зам дагуу тохижуулсан нийтийн эзэмшлийн талбай, явган хүний дамжин өнгөрөх хөдөлгөөн, богино хугацааны амралтад зориулагдсан янз бүрийн өргөнтэй зурвас хэлбэртэй ногоон байгууламж юм.	2 талаараа автозамаар хязгаарлагдсан өргөн (18-50м) чөлөө юм.	
1.4.1			Н4.1 Цуваа цэцэрлэг	Хот суурин газрын замыг салхи шуурга, ус цасны нөлөөгөөр элэгдэж, эвдрэхээс хамгаалах, явган замыг машин замаас тусгаарлах, барилгын нүүр, ханыг чимэглэж хөшиг болгон ашигладаг ногоон байгууламж юм.	Авто замын дагуу мод, сөөг цувуулан суулгасан ногоон байгууламжийн хэлбэр юм.	
1.4.2		Н4	Н4.2 Гудамж, зам талбайн ногоон байгууламж	Явган зорчигч, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, түр амрахад зориулагдсан ногоон байгууламж юм.	Гэр хорооллын сууц бүхий суурьшил дах гудамж, зам талбайн ногоон байгууламж хамаарна.	
1.4.3			Н4.3 Тусгаарлах зурвас	Гудамж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудлын зурвас газар, үйлдвэрлэлийн бүс, хог хаягдлын цэг, оршуулгын газар зэрэг тусгай зориулалтын үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламжийг олон нийт, орон сууцны бүсээс тусгаарлах ногоон байгууламж юм	Мод, сөөгөөр тусгаарлах, хамгаалах зориулалттай ногоон зурвас юм.	
1.5			Цэцэрлэгжүүлсэн талбай	3 га хүртэлх талбай бүхий орон сууцны хорооллын амралт зугаалгын, спорт, амралт, тоглоомын байгууламжаар хангасан нийтийн хэрэгцээний цэцэрлэгжүүлсэн талбайн юм	Талбайн зохион байгуулалтын хувьд зам, тоглоомын талбай, зулэг, цэцгийн мандал, мод сөөгийн бүлэглэлийг багтаана.	
1.5.1			Н5.1 Бичил цэцэрлэг	1 га хүртэлх хэмжээтэй, богино хугацааны амралт, явган хүний дамжин өнгөрөх хөдөлгөөнд ашиглагдах бичил цэцэрлэг юм.	Нэг төрлийн агуулгаар тохижуулагдсан бичил талбайнууд хамаарагдана.	

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1.5.2		H5	H5.2	Дээврийн цэцэрлэг	Дээврийн цэцэрлэг нь барилга байгууламжийн дээвэр дээрх орчныг тохижуулж, агаарыг цэвэршүүлж, бичил уур амьсгалыг сайжруулахаас гадна хотын ногоон бүрхүүлийг нэмэгдүүлэх боломжтой ногоон байгууламж юм.	Цэцэрлэгжүүлэх боломжтой барилга байгууламжийн дээврийн талбай хамаарна.
1.6				Байгалийн ногоон бүс	Байгалийн унаган төрхөд түшиглэн иргэдийн амралт зугаалга, аялал жуулчлалын зориулалтаар ашиглах бүс нутагт байгуулсан ногоон байгууламж юм.	
1.6.1		H6	H6.1	Голын ай сав	Хот суурин газрыг дамжин өнгөрдөг голын ай сав дагуу амрагч, аялагчдад зориулагдсан ногоон байгууламж юм.	Хотыг дамжин өнгөрдөг голын ай, сав газрууд хамаарна.
1.6.2			H6.2	Уулын ландшафт	Уулын ландшафтын онцлог байдлыг харгалзан хотыг тольдох өндөрлөг, амралт, аялал зугаалгын зориулалтаар тохижуулсан ногоон байгууламж юм.	Уулын ногоон бүс хамаарна.

## ХАВСРАЛТ 2.

## ХЯЗГААРЛАГДМАЛ ЗОРИУЛАЛТТАЙ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1	Х	Хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламж		Ангиллын ногоон байгууламж	Эмнэлгийн, хүүхдийн боловсрол, шинжлэх ухааны байгууллагууд, аж үйлдвэрийн газрууд гэх мэт хамаарагдана.	
1.1				Сургуулийн ногоон байгууламж	Сургуулийн эдэлбэр газарт хүүхдийн боловсрол, танин мэдэхүй, амрах, аюулгүй байдлыг хангасан ногоон байгууламж юм.	
1.1.1			X1.1	Их сургуулийн эдэлбэр газрын ногоон байгууламж	Коллеж, их дээд сургуулийн багш, суралцагчдын хэрэгцээнд нийцүүлэн орон зайн хэлбэр, ургамлын хослол зэргээр орчны ая тухтай байдлыг бүрдүүлэх юм.	
1.1.2		X1	X1.2	Ерөнхий боловсролын сургуулийн эдэлбэр газрын ногоон байгууламж	Сургуулийн орчны ногоон байгууламжийн онцлог хүмүүнлэг, мэдлэг боловсрол суурилсан ландшафт бүхий орчин бүрдүүлж, суратчдын ёс суртахууны чанарыг сайжруулах, бие даан суралцах урам зоригийг идэвхжүүлэх, биологийн практик хичээлийг хэрэгжүүлэхэд кампусын ургамлын нөөцийг ашиглах зэрэг өндөр ач холбогдолтой.	Сурч боловсроход таатай орчин бүрдүүлэхэд зориулагдсан ногоон байгууламжууд хамаарна.
1.1.3			X1.3	Хүүхдийн цэцэрлэгийн эдэлбэр газрын ногоон байгууламж	Цэцэрлэгийн орчныг ногооруулах ажлыг шинжлэх ухаан, оновчтой, аюулгүй байдал хангасан хүүхдийн өсөлт хөгжил, танин мэдэхүүд зориулсан ногоон байгууламж байна.	Хүүхдийн өсөлт хөгжил, танин мэдэхүүн зориулалт бүхий ногоон байгууламж хамаарна.
1.2	X	X2	X2.1	Эмнэлэг, сувиллын газрын ногоон байгууламж	Эмнэлэг нь янз бүрийн хэрэглээний шаардлага бүхий хэсгүүдээс бүрдэх бөгөөд ерөнхий төлөвлөлт функциональ шаардлагын дагуу хийнэ. Тухайлбал эмчилгээний, ерөнхий хэсгүүдэд хувааж амбулаторийн, хэвтэн эмчлүүлэх, туслах хэсгүүд зэрэгт хуваан тохижуулна.	Эмнэлэг, сувиллын үйлчилгээний зориулалтаас хамааран цэцэрлэгжүүлсэн эдэлбэр газрууд хамаарна.



№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
			Дагалдах	ногоон байгууламж	Аж ахуйн үйл ажиллагааны зориулалттай байгууламжийг хэлнэ.	терөл бүрийн ногоон
1.3			X3.1	Аж ахуй нэгж, байгууллагын эдэлбэр газрын ногоон байгууламж	Аж ахуй нэгж, байгууллагуудад хамааралтай эдэлбэр газрын орчныг ландшафтыг сайжруулах, хамгаалахад анхаарч, тохижилт, гоёл чимэглэлийн чиг үүрэгтэй ногоон байгууламж юм. Талбайн байршлаас хамааруулан өнгө, үзэмж сайтайгаар төлөвлөх.	Төрийн болон хувийн өмчит байгууллагын эдэлбэр газар дах ногоон байгууламжууд хамаарна.
1.4			X3.2	Үйлдвэрийн зориулалттай эдэлбэр газрын ногоон байгууламж	Үйлдвэрийн ногоон байгууламж нь тоос шороо, дуу чимээг бууруулах, үйлдвэрийн орчны зохих үр нөлөөг бууруулахыг шаарддаг. Мөн үйлдвэрийн онцлог, хэв маягийг бүрэн илэрхийлэх ногоон байгууламж байна.	Үйлдвэрлэл явуулж байгаа байгууллагуудын эдэлбэр газрын ногоон байгууламж хамаарна.
1.5		X3	X3.3	Худалдаа, үйлчилгээний зориулалттай эдэлбэр газрын ногоон байгууламж	Худалдаа, үйлчилгээний зориулалттай ногоон байгууламж нь үйлчлүүлэгчдийн анхаарлыг татах, аюулгүй байдлыг хангах, гоёл чимэглэлийн чиг үүрэгтэйгээр төлөвлөсөн ногоон байгууламж юм.	Том, жижиг бүх худалдааны төвийн эдэлбэр газар дах ногоон байгууламж хамаарна.
1.6			X3.4	Логистик хадгалалтын газрын ногоон байгууламж	Логистик хадгалалтын эдэлбэр газрын ногоон байгууламж юм.	Логистикийн үйл ажиллагаа эрхэлж байгаа газрууд хамаарна.
1.7			X3.5	Авто замын дагуух ногоон байгууламж	Авто замын дагуух ногоон байгууламж нь авто машинаас ялгарах утаа тортог, дуу чимээг шингээх, хэт халалтыг бууруулах, явган хүнээс тусгаарлах зориулалттай.	Авто замын сүлжээ дагуух ногоон байгууламж хамаарна.

## ХАВСРАЛТ 3.

## ТУСГАЙ ЗОРИУЛАЛТТАЙ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ

№	Ангиллын код			Ангиллын нэршил	Агуулга	Тайлбар
	Том ангилал	Дунд ангилал	Жижиг ангилал			
1		Тусгай зориулалттай ногоон байгууламжийн төлөвлөлт		Ариун цэвэр, усны эх үүсвэрийн хамгаалалт, хамгаалалт-нөхөн сэргээлт, гал түймрээс урьдчилан сэргийлэх бүс, оршуулгын газар зэрэг багтана.		
1.1			Хамгаалалтын ногоон байгууламж	Эрүүл ахуй, хөл хорих, аюулгүй байдал, экологийг хамгаалах үүрэгтэй, зорчигч ногоон байгууламж руу орж болохгүй.		
1.1.1	T	T1	T1.1 Хамгаалалтын ойн зурвас (Ногоон зурвас)	Салхины хамгаалалт, элсний нүүлт, тариалангийн талбайн хамгаалалт, бэлчээрийн хамгаалалт, эргийн хамгаалалт, бохирдлоос урьдчилан сэргийлэх, зам болон төмөр замаас хамгаалах, өндөр хүчдэлийн шугамаас хамгаалах ногоон байгууламж болон нийтийн хэрэгцээний байгууламжийг хамгаалах ногоон байгууламж зэрэг багтана.	Хамгаалалтын ойн зурвас хийх шаардлагатай бүс хэсгүүд хамаарна.	
1.1.2			T1.2 Усны эх үүсвэрийг хамгаалах ногоон байгууламж	Хэт их ашиглалт, бохирдлоос сэргийлэхийн тулд усны эх үүсвэрийг хамгаалах ногоон байгууламж юм.	Голын эх, булаг, шанд болон усны эх үүсвэрийн ландшафтыг зориудаар хамгаалсан ногоон байгууламж хамаарна.	
1.2		T2	Оршуулгын газрын ногоон байгууламж	Цимээгүй хотын эдэлбэр газрын орчны бохирдлыг багасгах, байгаль экологид эергээр нөлөөлөх ногоон байгууламжийг төлөвлөнө	Бүх төрлийн чимээгүй хотын ногоон байгууламжууд хамаарна.	

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-02-06.
- Хот, тосгоны төлөвлөлт. Барилгажилтын норм ба дүрэм БНбД 30.01.04.
- Хот суурины гудамж, зам төлөвлөлт БНбД 32-01-04.
- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНбД 30-01-04.
- Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн авах. Ерөнхий шаардлага MNS6263:2011.
- Цэцэрлэгжүүлсэн талбайг шалгаж, ашиглалтад хүлээн авах. Ерөнхий шаардлага MNS6263:2011.
- Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах MNS IOS 11091:2007
- Хотын ногоон байгууламж. Тодорхойлолт ба нэр томъёо. ГОСТ 28329 – 89
- Хотуудын ногоон байгууламж. Нэр томъёо, тодорхойлолт. ГОСТ 28329-89.
- Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнгийн төлөвлөлт GB 51192-2016.
- Орон сууцны хорооллын ногоон байгууламж төлөвлөлт DG 5301/T 21-2017
- <https://www.mlsp.gov.mn/>
- <https://standartgost.ru/>







Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Наадамчдын зам 1200, Арцатын ам, 4 дүгээр хороо,  
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17100



70118030, 70118040



[www.standard.ub.gov.mn](http://www.standard.ub.gov.mn)



Хотын стандарт, хяналтын газар